

ТАНИЛЦУУЛГА

“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”

Монгол, Япон хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь айлчлал солилцоо, цэргийн сургалт, бэлтгэл, Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг хоорондын хамтын ажиллагаа, Инженерийн цэрэг болон цэргийн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалт, дадлагад оролцох зэрэг өргөн хүрээтэй хөгжиж ирсэн. Хамтын ажиллагааны хүрээ тэлэхтэй уялдуулан хамтын ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, шинээр байгуулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Хоёр улсын Засгийн газар хооронд 2015 онд “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаварыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр”, Батлан хамгаалах яамд хооронд 2012 онд “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг”-ийг байгуулсан бөгөөд 2024 оны 02 дугаар сард Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын Япон Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр уг санамж бичгийн шинэчилсэн баримт бичигт гарын үсэг зурсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр байгуулсан “Монгол Улс, Япон Улсын Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудлаар ГХЯ-аас чиглэл авч, хоёр талын ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Хоёр талын ажлын хэсгийн бэлтгэл уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр цахимаар зохион байгуулсан ба хэлэлцээрийн албан ёсны зөвшилцлийг эхэлж, талууд 2024 оны 2, 3, 5, 6, 7 дугаар саруудад хэлэлцээрийн төслийг харилцан солилцсон. Хоёр талын ажлын хэсгийн уулзалтыг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр дахин цахимаар зохион байгуулж, хэлэлцээрийн төслийн агуулгыг эцэслэн тохиролцоод байна.

Уг Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулснаар хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдаж, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, бүс нутагт цэргийн илтгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэж, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Иймд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлсний дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.